



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/687

Булгай сум

Г Гэрээ байгуулах эрх олгох тухай Г

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.2, 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа Сувиллын яслийн үйл ажиллагааг явуулахад 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/280 дугаар захирамжаар байгуулсан түрээсийн гэрээний хугацаа дууссантай холбогдуулан тус яслийн үйл ажиллагааг 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг дуустал иргэн Ж.Оюунчимэг /ПЮ62071402/ -тэй гэрээ байгуулан, 348 м2 талбай бүхий барилгад шилжүүлэн, үйл ажиллагаа явуулахыг Сувиллын яслийн эрхлэгч (С.Мягмарсүрэн)-д үүрэг болгосугай.

2. Ж.Оюунчимэгийн барилгын түрээсийн төлбөрт 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 15-ний өдрийг хүртэлх хугацаанд эд хөрөнгө хадгалах байрны түрээсийн сарын төлбөрийг 500,000 (таван зуун мянга) төгрөг, 2024 оны 08 дугаар сарын 15-наас 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд үйл ажиллагаа явуулах байрны түрээсийн төлбөрийг сарын 5,000,000 (таван сая) төгрөгөөр тооцож, түрээсийн гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

3. Тус цэцэрлэгийн барилгын түрээсийн зардлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлэн санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ